

РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВИЙН

2026 оны 2 дугаар улирлын ажлын тайлан

Нэг. Албан бичиг шийдвэрлэлт:

Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв (РДӨНХТ)-д 2026 оны 2 дугаар улиралд нийт 63 албан бичиг ирснийг шийдвэрлэсэн байдал:

Харилцан нөлөөллийн хэмжилт хийлгэх албан бичиг нийт 25 ирсэн. Үүнд:

- Улаанбаатарт хотод 33 байршилд;
- Хөдөө орон нутагт 15 байршилд хэмжилт, хяналт хийж шийдвэрлэсэн.


Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүй түвшний хэмжилт хийлгэх албан бичиг нийт 9 ирсэн. Үүнд:

- Улаанбаатар хотод 4 байршилд;
- Хөдөө орон нутагт 6 байршилд хэмжилт хийж дүгнэлт гаргасан.

2026 оны 2 дугаар улирлын “Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилтийн тайлан”-гуудтай тус хорооны вэб хуудсанд байршуулсан, дараах холбоосоор орж танилцах боломжтой.

<https://crc.gov.mn/posts/2026-06-24-02>

Хүсэлт, мэдэгдэл, хариу бусад төрлийн нийт 29 албан бичиг ирсэн.




2 дугаар улирлын хугацаанд чиг үүргийн дагуу нийт 79 албан тоот боловсруулан гаргаж, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Үүнд:

Харилцан нөлөөллийн хэмжилтийн тайлан	ЦСО-ны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүй түвшний хэмжилтийн тайлан	Зөрчил арилгуулах албан шаардлага	Бусад
43	7	16	13

Радио давтамжийн зурвасын харилцан нөлөөллийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хорооны www.crc.gov.mn цахим хуудсанд байршуулсан, дараах холбоосоор орж маягтыг бөглөж info@crc.gov.mn хаягт илгээнэ үү.

Линк: <https://crc.gov.mn/radio-davtamzhijn-harilcan-n-l-l-shalguulah-huudas>

Нийт бүртгэгдсэн харилцан нөлөөллийн эх үүсвэрийн төрөл, ангилал:



Нөлөөллийн эх үүсвэрийн ихэнх хувийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын сүлжээний чанарыг сайжруулах зорилгоор ашиглаж буй баталгаажуулаагүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж эзэлж байна. Иймд иргэд болон аж ахуйн нэгж байгууллагууд сүлжээний чанарыг сайжруулах шаардлагатай тохиолдолд баталгаажуулаагүй тоног төхөөрөмж ашиглахын оронд үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдэд албан хүсэлт гаргаж, тухайн орчны сүлжээний чанар, хамрах хүрээг сайжруулах арга хэмжээг авхуулах боломжтой.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллага нь сүлжээ өсгөгч төхөөрөмжийн үйл ажиллагааг зогсоох шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдолд Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нь мэргэжил арга зүйн зөвлөмж өгч сүлжээ өсгөгч төхөөрөмжийг унтраалгаж нөлөөллийг арилгах арга хэмжээ авдаг. Хэрэв иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь сүлжээ өсгөгч төхөөрөмжийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр үргэлжлүүлэн ашигласан тохиолдолд “Зөрчлийн тухай” хуульд зааснаар “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулийн дагуу холбогдох хариуцлага хүлээлгэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХӨРӨӨ

ҮҮРЭН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ӨСГӨГЧ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ ХУУДАС

Иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй дараах төрлийн баталгаажуулалтад хамрагдаагүй, тохирлын гэрчилгээгүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж нь өргөн зурвасаар хууль бус дохио өрнүүлэн тусгай зөвшөөрөлтэй үүрэн холбооны радио давтамжийн зурваст радио давтамжийн нөлөөлөл үүсгэж улмаар үүрэн холбооны сүлжээг тасалдуулж, олон нийтийн эрх ашгийг хохироож байна.



Дараах хуулийн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:



Радио долгионы тухай хууль

7.1. Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

8.1. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

8.2. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

14.1. Дараахь төрлийн радио төхөөрөмж ашиглахад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авахгүй:

- 14.1.1. бүх төрлийн зурагт радио, радио хүлээн авагч;
- 14.1.2. эмчилгээ, оношилгооны радио төхөөрөмж;
- 14.1.3. техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмж.

19.2.1. энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд радио төхөөрөмж импортлох, үйлдвэрлэх, худалдахыг сонирхогч этгээд Зохицуулах хороотой радио давтамжийн талаар урьдчилан тохирох;

Хуулийн хариуцлага:



Зөрчлийн тухай хууль

14.2 дугаар зүйл. Радио долгионы тухай хууль зөрчих

5. Бусад радио холбоо, эсхүл радио төхөөрөмж хэрэглэгчийн ажиллагаанд:

- 5.1. харилцан нөлөөлөл учруулсан;
- 5.2. хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан;
- 5.3. баталгаажуулаагүй төхөөрөмж ашигласан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Тусгай зөвшөөрөл, эсхүл эрхийн бичиг эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд хууль бусаар саад учруулсан бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Иймд үүрэн холбооны сүлжээний чанар муу тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь тухайн үүрэн холбооны үйлчилгээ үзүүлж буй компанидаа хандан сүлжээний чанар сайжруулах хүсэлтээ гаргах, тохирлын баталгаатай сүлжээ өсгөгч төхөөрөмж ашиглахыг зөвлөж байна.

Хаяг: Метро бизнес төв А-блок 5 давхар Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033,
Утасны дугаар: 11-304258, 1800-1858, Вөб хуудас: www.crc.gov.mn, Цахим шуудан: info@crc.gov.mn

Хоёр: Томилолтын тайлан, газар дээрх хяналт хэмжилт

ХХЗХ-ны РДӨНХТ-ийн инженерүүд Монгол Улсын 13 аймаг, 22 сум, 5 боомтын нутаг дэвсгэрт нийт 31 хоног ажиллаж, 11,055 км замыг туулж дараах хэмжилт, хяналтыг хийж зохицуулалтын арга хэмжээг авч ажилласан.

№	Хугацаа	Тушаалын дугаар	Хамрагдсан бүс нутаг	Гүйцэтгэсэн ажил
1.	2026.04.27-05.07	A/88	Өвөрхангай аймгийн Нарийнтээл сум, Төв аймгийн Эрдэнэсант сум, Булган аймгийн Рашаант сум, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Бууцагаан сум, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Дэлгэр сум, Бургастайн боомт, Ховд аймгийн Манхан, Зэрэг, Жаргалант сум, Булган боомт	Говь-Алтай аймгийн Бугат сум дахь Бургастай, Ховд аймгийн Булган сум дахь Булган боомтуудад радио давтамжийн зурвасын хэмжилт, РТҮС-УТҮГ-ын их чадлын радио өргөн нэвтрүүлгийн станцуудын хамрах хүрээний хэмжилт, хяналтуудыг хийж гүйцэтгэсэн.
2.	2026.05.11-05.17	A/97	Дорнод аймгийн Хэрлэн сум, Хавирга, Баянхошуу боомт, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Эрдэнэцагаан сум, Бичигт боомт, Хэнтий аймаг	Скайтел ХХК, Юнител ХХК болон Жимобайл ХХК-аас ирүүлсэн албан бичгүүдийн хүрээнд 3 байршилд харилцан нөлөөллийн эх үүсвэрийг тогтоох хэмжилт, хяналтыг хийж 2 ширхэг баталгаажуулаагүй үүрэн холбооны сүлжээ өсгөгч төхөөрөмж унтраасан. Дорнод аймгийн Хавирга, Баянхошуу боомт, Сүхбаатар аймгийн Бичигт боомтуудад радио давтамжийн зурвасын хэмжилт, РТҮС-УТҮГ-ын их чадлын радио өргөн нэвтрүүлгийн станцуудын хамрах хүрээний хэмжилт, хяналтуудыг хийж гүйцэтгэсэн.
3.	2026.05.13-05.15	A/98	Төв аймгийн Баянцогт сум, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Цагааннуур сум	Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-ын Радио холбооны товчоо (Radiocommunication Bureau)-ноос ирүүлсэн хүсэлтийн дагуу радио давтамжийн зурвасын ашиглалтын байдлыг тодорхойлох хэмжилтийг хийсэн.
4.	2026.06.08-06.19	A/122	Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Булган аймгийн 2Булган сум, Хөвсгөл аймгийн Тариалан, Мөрөн,	Скайтел ХХК-ийн албан тоот хүсэлтийн дагуу 2 байршилд харилцан нөлөөллийн эх үүсвэр тогтоох хэмжилт, Стесс Северс ХХК-ийн албан тоот хүсэлтийн дагуу 1 байршилд ЦСО-ны хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. ОБЕГ-аас ирүүлсэн албан тоот хүсэлтийн дагуу Онцгой

		Цагаан-Уул, Галт, Хатгал сум	байдлын ерөнхий газрын анги, салбаруудын ашиглаж буй радио станцын долгионы тархалтийн хэмжилт, богино болон хэт богино долгионы радио станцын гаралтын чадал, антены өсгөлт болон фидерийн байгууламжид хэмжилт хийж албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.
Томиллолтоор ажилласан аймгийн төвүүдэд 30 МГц-6 ГГц радио давтамжийн хэрэглээг тодорхойлох зурвасын хэмжилтүүдийг хийж гүйцэтгэсэн.			

Гурав. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа:

Радио долгионы зохистой хэрэглээг төлөвшүүлэх, холбогдох хууль, дүрэм журмыг сурталчлах чиглэлээр 2026 оны 2 дугаар улиралд дараах арга хэмжээг зохион байгуулсан.

1. Хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Экологийн цагдаагийн төвийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Тус сургалтыг РДӨНХТ-ийн Ерөнхий инженер М.Болдбат, Хөдөлгөөнт хяналтын инженер М.Энхзориг нар удирдан явуулж, Радио долгионы тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам, техникийн нөхцөл шаардлага, хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулав. Уулзалтын төгсгөлд хоёр байгууллагын төлөөллүүд ирэх 2027 оны төлөвлөгөөт ажлуудыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх, хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцож, цаашдын чиглэлийг тодорхойлсон.



2. Хил хамгаалах ерөнхий газрын хүсэлтийн дагуу 2026 оны 05 дугаар сарын 07-ний өдөр Хил хамгаалах ерөнхий газрын 0151 дугаар ангийн холбооны ангийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Тус сургалтыг Хөдөлгөөнт хяналтын ахлах инженер А.Алтанхуяг, хөдөлгөөнт хяналтын инженер М.Энхзориг нар удирдан явуулж, Радио долгионы тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам, техникийн нөхцөл шаардлага, хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулав. Мөн цаашид тоног төхөөрөмжийн аюулгүй байдал болон хяналтын чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан тохиролцсон.



3. Улаанбаатар хотын хэмжээнд 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Road Expo, Horeca Mongolia Expo, Mongolia Mining Expo, Agro Expo, Barilga Expo зэрэг үзэсгэлэн арга хэмжээнд оролсон нийт 55 аж ахуйн нэгж, байгууллагад харилцааны гар станц ашиглахтай холбоотой зөвлөмж, мэдээллийн хуудсыг тарааж, холбогдох хууль, дүрэм журмын талаарх мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХӨРӨӨ

ХАРИЛЦААНЫ РАДИО СТАНЦ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ ХУУДАС

Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн үйл ажиллагааны нэг нь Монгол Улсын төрийн өмч, байгалийн хязгаарлагдмал нөөц болох радио долгионыг үндэсний хэмжээнд төлөвлөх, хуваарилах, радио долгионы хяналтыг хэрэгжүүлэх болон харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах үйл явц юм.

Радио долгионы тухай хуулийн 4.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь **Монгол Улсын төрийн өмч мөн**” гэж заасан.



Иргэн, хуулийн этгээд нь радио станцыг радио давтамж ашиглах эрхийн бичиггүй буюу хууль бусаар ашигласнаар зөвшөөрөл бүхий хэрэглэгчдийн радио давтамжийн зурваст нөлөөлөл үүсгэж үйл ажиллагааг нь доголдуулдаг. Энэ нь хууль ёсны хэрэглэгчдийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулан ярианы чанар муудах, шуугиан үүсэх, яриа давхардаж сонсогдох зэрэг асуудлуудыг үүсгэдэг. Мөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдан үйлдвэрлэлийн осол гарах аюултай нөхцөл бүрдэх эрсдэлтэй. Радио станцыг радио давтамж ашиглах эрхийн бичиггүй ашиглах нь Радио долгионы тухай хуулийн дараах заалтуудыг зөрчиж байна. Үүнд:



Радио долгионы тухай хууль

7.1. Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

8.1. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

Хуулийн хариуцлага:

21.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Зөвшөөрөл авч ашиглах нь:

- * Таны зөвшөөрөлтэй радио давтамжийг бусад хуулийн этгээд, иргэн давхар ашиглахгүй;
- * Давхар өөр яриа сонсогдох, шуугиан үүсэх, бусад радио төхөөрөмжүүдээс радио давтамжийн нөлөөлөл үүсгэсэн тохиолдолд ХХЗХ-ноос радио давтамжийн нөлөөллийг арилгахыг шаардах эрхтэй;
- * Өөрийн сүлжээнд болон бусад радио төхөөрөмжүүдэд радио давтамжийн нөлөөлөл үүсгэхгүй.



Иймд харилцааны радио станц ашиглах бол ХХЗХ-нд хандаж **Радио давтамж ашиглах эрхийн бичиг авч**, зөвшөөрлөөр олгогдсон радио давтамжийг өөрийн төхөөрөмжүүдэд тохируулах шаардлагатай.

Тус QR кодыг уншуулж Радио давтамж ашиглах эрхийн бичиг авахад бүрдүүлэх бичиг баримтуудтай танилцана уу.



Тус QR кодыг уншуулж Радио давтамж ашиглах эрхийн бичгийг цахимаар авах видео заавартай танилцана уу.



Хаяг: Метро бизнес төв А-блок 5 давхар Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033,
Утасны дугаар: 11-304258, 1800-1858, Веб хуудас: www.crc.gov.mn, Цахим шуудан: info@crc.gov.mn

4. Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж худалдан борлуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөгч нарт 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр “Радио долгионы хяналт, хууль бус хэрэглээ, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын хүрээнд “Радио долгионы тухай хууль, хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээлэл харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалттай холбогдох журам шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал солилцлоо. Түүнчлэн сургалтад оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч, цаашид эрх зүйн орчин, баталгаажуулалтын тогтолцооны хүрээнд шат дараатайгаар хамтран ажиллахаар санал нэгдлээ.

